



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/35

Есөнбулаг сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Үнэлгээний хорооны 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 32 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. ГААХААГ/20250202139 дугаартай аймгийн аюулгүйн нөөцөд өвс нийлүүлэх ажлыг "Соёмбо өгөөж хишиг" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Очир)-т олгосугай.

2. Ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг бөлөвсруулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журмын дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Ж.Очир)-т үүрэг болгосугай.

3. Ажлын чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

